

ЗҮҮН ХОЙТ АЗИЙН БҮС НУТГИЙН ОРНУУДЫН
ХАМТЫН АЖИЛЛАГАА, МОНГОЛ УЛС*

Ч.Далай

Нэгэн зуун дуусч нөгөө зуун эхлэх босгон дээр хүн төрөлхтөн тулж ирээд байна. Өнөөгийн олон улсын байдал хэдэн жилийн өмнөхөөс эрс өөр боллоо. "Хүйтэн дайны" үе дуусгавар болж, дэлхий ертөнц хүчний хоёр туйлт тогтолцооноос олон туйлт тогтолцоонд шилжиж байна. Үүнийг хуучин ЗХУ задран унаж, АНУ-ын эдийн засгийн ноёрхол ямар нэгэн хэмжээгээр алдагдаж байгаагай холбон үзэж болох юм. Дэлхийн улс орнууд ачаалал багатай гадаад бодлого явуулахыг эрхэмлэх болсон өнөө үед зэвсэглэлийг, тэргүүн ээлжинд цөмийн зэвсэглэлийг хорогдуулж, түүнээс хэмнэгдэх хөрөнгийг улс түмний эдийн засаг, нийгмийн хөгжилд зориулах шинэ боломж нээгдэж байна. Өнөөгийн дэлхий дахины үйл явдал нийгмийн амьдралыг ардчилах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хүч хэрэглэхээс татгалзаж, улс төрийн аргаар зохицуулах чиглэлд эснэх болж байна. 90-ээд оны хүн төрөлхтний нийгэм-эдийн засгийн хөгжлийн зарим төвөгтэй зорилтыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын үүрэг өсөн нэмэгдэж, түүний үйл ажиллагаа өргөжин тэлж байна.

Дэлхийн хамтын нийгэмлэг, улс гүрнүүд нийгэм-эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн загварыг урьдал болгохоорсоо байгаль газар зүйнхээ нөхцөлд тохируулан тогтвортой хөгжлийг хангахад илүү анхаарал тавих нь чухал гэдэг үзэл санааг эрхэмтэх болж байна.

Хүн төрөлхтөн экологийн аюулгүй орчинд, байгальтайгаа эвсэн амьдрах шаардлага өнөөдөр хэзээ хэзээнээс илүү хурцаар тавигдаж байна. Энэ шаардлага саяхан Бразильд болсон байгаль орчин, хөгжлийн асуудлаархи НҮБ-ын бага хурал, түүнээс гаргасан баримт бичигт өргөн тусгалаа олсон юм.

Дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий хандлага бүсчилэх чиглэлтэй болж буй өнөө үед Өрнөд-Дорнод, Умард-Өмнөд гэж хуваах үзэл баримтлал утгаа алдаж байгаа нь улам тодорхой болж байна. Манай гаригийн улс гүрнүүд Европ, Америк, Ази гэсэн гурван том туйлд хуваагдаж болохыг ч үгүйсгэх аргагүй.

Дээр дурьдсан үзэл санаанаас ургуулан бодоход энэ бүхэн нь олон улсын харилцааны өнөөгийн тогтолцоог шинэчлэх замаар дэлхийн шинэ дэг журмыг аажмаар тогтоох суурь дэвсгэрийг бий болгоход чиглэсэн нааштай эхлэлүүд гэж үзэж болох байна.

Тив дэлхийн уялдлага холбоог дагалдан бидний суудаг Ази тив, Номхон далайн сав газар бас л бүс нутгийн хамааралтай үйл явцад шилжиж, тэр нь жилээс жил тэлэн өргөжсөөр байна. 80-аад оноос дэлхий дахины анхаарлыг Ази, Номхон далайн бүс нутаг өөрийн эрхгүй татаж, одоо улам өсөн нэмэгдэж байгаа нь нэгэнт тодорхой боллоо. XXI зуун бол Ази, Номхон далайн бүс нутгийн эрин үе болно хэмээн дэлхийн хэвлэлд олонтаа бичиж, улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн, судлаачдын илтгэл, хэлсэн үгэнд байнга тусгагдаж байгаа нь санамсаргүй хэрэг бишээ. Нийт Ази, Номхон далайн улсуудыг хамарсан НҮБ-ын эдийн засаг-нийгмийн байгууллагуудын зэрэгцээ өргөн уудам Ази, Номхон далайн бүс нутаг дооноо Зүүн, Зүүн өмнөд, Өмнөд, Өрнөд Ази болон Номхон далайн Өмнөд нутаг гэх зэргээр тодорхой хэсгүүдэд хуваагдан тэдгээрт оршин буй орнууд өөр хоорондоо хүч

Ч. Далай. Зүүн хойт Ази судлалын төвийн захирал, түүхийн ухааны доктор, профессор.

* "Дэлхийн шинэ дэг журамд Зүүн хойт Азийн эзлэх байр суурь" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлийн үндсэн дээр энэ агуулгийг олгосон.

чармайлтаа нэгтгэн хамтран ажиллах, бие биесийг дэмжих зорилгоор комисс, хамтын ажиллагаа, нийгэмлэг, бага хурал, чуулга уулзалт гэх зэрэг янз бүрийн хэлбэрийн олон талын хамтын ажиллагааг явуулж байна.

Ази, Номхон далайн Умард хэсэгт өөр өөр улс төрийн системтэй, голдуу их гүрнүүд оршдог учир байдал арай өвөрмөц юм. Сүүлийн жилүүдэд дэлхий дахины байдалд гарч байгаа нааштай уур амьсгалын нөлөөгөөр Ази, Номхон далайн умарт хэсэгт хамаарагдах улс орнууд, ялангуяа их гүрнүүд харилцаагаа аль болохоор хэвийн болгохыг чармайж, сөргөлдөөний байдлаас зоригтой гарч, итгэлцэлд тулгуурласан идэвхтэй хамтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. Энэхүү хоёр талын ба олон талын харилцан үйлдлийн явцад "Зүүн хойт Азийн бүс нутаг" гэдэг томъёолол зөвхөн газар зүйн ойлголт байхаа больж, бас улс төр, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааны агуулгыг илэрхийлэх болж дэлхийн улс төр-эдийн засгийн хэллэгт байр сууриа нэгэнт эзлэх боллоо.

Зүүн хойт Азийн бүс нутагт багтах улс орон хөгжлийн түвшнээр их ялгаатай бөгөөд тэдгээрийн нийгмийн байгуулал ч янз бүр, түүх соёлын уламжлал ч харилцан адилгүй. Гэхдээ газар зүйн хувьд хөршилсөн, харилцан хамаарал ихтэй, стратегийн чухал ач холбогдолтой бүс нутаг мөн. Тус бүс нутаг хамтын ажиллагаа тогтоон өргөжүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх нөөц баялаг, нөхцөл боломж ихтэй юм. Өөрөөр хэлбэл тус бүс нутгийн улс орон бүр харилцан нэг нэгийгээ сэлбэн нөхөх өөрийн гэсэн давуулаг онцлогуудтай юм. Тухайлбал Орос улсын Сибирь, Алс Дорнодын нутаг бол нүүрс, байгалийн хий, нефть зэрэг газрын хэвлийн арвин их баялагтай, цэвэр ус, модны асар их нөөцтэй. Гэвч энд эдийн засгийн хөгжлийн төвшин төдий л өндөр бус, хөдөлмөрийн хүч дутагдалтай бүс нутаг юм. Зүүн хойт Азийн бүсэнд хамаарагдах Хятадын мужууд байгалийн чамлалтгүй арвин баялагтай, хөдөлмөрийн хүчний нөөц ихтэй, хөдөө аж ахуй нэлээд сайн хөгжсөн бүс нутаг боловч шинжлэх ухаан-техникийн хөгжлөөр харьцангуй сул, хөдөлмөрлөх хүчний мэргэжлийн төвшин өндөр бус. Япон улс эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн төвшингөөр өндөр, ерөнхий хөгжлөөрөө дэлхийд хоёрдугаарт, Азид тэргүүнд орж байгаа боловч газар нутаг бага, байгалийн нөөц баялаг хомс орон юм. Дэлхийн шинэхэн үйлдвэржсэн орнуудын нэг Өмнөд Солонгос эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хөгжлийн хурдац өндөртэй, хөгжлөөр дэлхийн төвшинд ойртож яваа авч, дотоодын зах зээл багатай, түүхий эд дутагдалтай орон юм. БНАСАУ байгалийн зохих баялагтай, хөдөлмөрийн хүчний нөөцтэй, аж үйлдвэр муугүй хөгжсөн боловч шинжлэх ухаан-техникийн хөгжлийн төвшинөөр харьцангуй өндөр бүс орон юм. Монгол улс өргөн уудам нутагтай, байгалийн арвин баялагтай, хүн ам цөөн, сул хөгжилтэй орон юм. Тус бүс нутагт хамаарах АНУ, Канад улс хоёр өргөн уудам нутагтай, байгалийн нөөц баялаг, ажиллах хүчний арвин потенциалтай, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хөгжлөөр дэлхийн тэргүүний орнуудын нэг юм. Дээр дурьдсанаас үзэхэд манай бүс нутагт хөгжлийн төвшинөөр янз бүрийн улс багтан орж байгаа нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн хөгжилд гарсан нааштай өөрчлөлтийн ачаар тус бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагаанд урьд ашиглагдаагүй байсан нөөцүүдийг тэдгээрийн цаашдын хөгжил дэвшлийн үйл хэрэгт зориулах бололцоо бий болсон юм. Тухайлбал ОХУ-АНУ, ОХУ-БНХАУ-ын харилцааны нөөц хөдөлгөөнд орж, хоёр Солонгос эвлэрэн, харилцан үл довтолох, хамтран ажиллах тохиролцоонд хүрч, бүс нутгийн нэгэн нөлөөтэй хүчний төв болох төлөв харагдаж, зогсонги байсан Япон-ОХУ-ын харилцааны нөөцийг бүс нутгийн нэгэн чирхэг бодлого болгон хэрэгжүүлэх нөхцөл аажимдаа бүрэлдэх зэрэг хүчин зүйлс шинээр бий болж, Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа, интеграцийг цаашид бүрэлдүүлэн тогтооход тус дөхөм үзүүлж байна. Бүс нутгийн улсуудын Засгийн газар, ард түмний хүчин чармайлыг явцад тэдгээрийн

хоорондын хоёр талын болон олон талын харилцан ашигтай хамтын ажиллагааны үндэс суурь нийгмийн амьдралын олон салаа мөчирт бий болж, байнга өргөжих хандлагатай боллоо.

Сүүлийн үед Зүүн хойт Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаанд зарим шинэ хэлбэрүүд бий болж байгаа билээ.

БНХАУ, ОХУ, БНАСАУ хамтран НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн ивээл дор Түмэн голын сав газрын эдийн засгийн бүсийг эзэмших төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Түүнд Япон, БНСУ зэрэг бусад улс оролцох юм. Энэ төслийг ажил хэрэг болгоход Хятад, БНАСАУ-ын ажиллах хүч, Оросын түүхий эд, Япон, Өмнөд Солонгосын хөрөнгө капитал, техник, технологи чухал ач холбогдолтой байх болно. Энэ нь бүс нутгийн хэмжээний томоохон төсөл болох юм.

Өмнөд Солонгосын Засгийн газар БНСУ, БНАСАУ, БНХАУ-ын хооронд Шар тэнгисийн эргэн тойронд эдийн засгийн эвсэл байгуулах программ боловсруулж байна. Уг төсөлд 3 улсын хүч чармайлтыг нэгтгэн бүс нутгийн хөгжлийг ахиулах зорилт тавихдаа Өмнөд Солонгос хөрш орнуудын эдийн засагт хөрөнгө оруулан, технологи олгох, БНАСАУ түүхий эдийг, БНХАУ ажиллах хүчнийг гаргахаар төлөвлөж байна. Уг программыг биелүүлэх явцад эдийн засгийн бүх салбарт солонгос хоорондын солилцоог түргэтгэх, Хятад-Солонгосын хоёр талын харилцааг өргөжүүлэх боломж гарах бөгөөд энэ нь бас Солонгосын хойгт улс төрийн байдлыг сайжруулах ач холбогдолтой юм.

Орос, Японы хооронд бүс нутгийн чанартай, их цар хүрээтэй эдийн засгийн хамтын ажиллагааны эхлэл таг игдаж байна. Дорнод Сибирээс Япон хүртэл 8 мянган км орчим урт байгалийн хий дамжуулах хоолой тавих төсөл ид яригдаж байна. Японд жилд 42 тэрбум шоо дөрвөлжин метр шингэрүүлсэн хий нийлүүлэх энэ төслийг хэрэгжүүлэхэд Япон, АНУ, БНСУ, Европын пүүсүүд оролцох ажээ.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн үйл явцад зам тээвэр, холбоо харилцаа нэн дорвитой байр суурь эзлэх юм. Солонгосын өмнөд ба умард хэсгүүд, Хятад, Оросын Холбооны улс, Монголыг холбосон төмөр зам, авто зам тавих, агаарын харилцааг өргөтгөх асуудал сүүлийн үед ид яригдаж байна.

Зүүн өмнөд Азийн улсуудын холбооны Бруней, Индонез, Малайз, Сингапур, Тайланд, Филиппин зэрэг гишүүн орнууд ирэх 15 жилийн хугацаанд Европын хамтын нийгэмлэгтэй адил төстэй эдийн засгийн бүрэн хэмжээний хамтын нийгэмлэг байгуулахаар төлөвлөж байгаа нь Зүүн хойт Азийн орнуудын анхаарлыг зүй ёсоор татах учиртай.

Зүүн хойт Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны зарим нэг томоохон төслүүдээс цухас дурдахад ийм байна.

Өөрчлөлт шинэчлэлтийн жилүүдэд Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гэр бүлд бодитой нэгдэн орж, олон улсын байр суурь нь өргөжиж, нэр төр нь дээшилж байна. Энэ хугацаанд гадаад бодлогынхоо зарчим, зорилтуудыг шинэчилж, шинэ шинэ түншүүдтэй болж байна. Орчин цагийн Монгол улсын гадаад бодлогын нэгэн гол чиглэл нь Зүүн хойт Азийн улс орнуудтай өргөн харилцаа тогтоож, нягт хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал болж байна. Энэ бүс нутгийн улсуудтай хэлхээ холбоо тогтоон хамтын ажиллагааг өргүүлэхийг манай улс зорихдоо газар нутгийн ойр дөт тал, урьд их бага хэмжээгээр тогтоосон уламжлалт харилцаа, тэдгээр орнууд /ялаугуяа шинэ түншүүд/ манай өөрчлөн байгуулалтанд нааштай хандсгч хандлага, мөн эдгээр улсын техник технологи, аж ахуйг удирдах удирдлагын хөгжлийн өндөр түвшин, бас бус хүчин зүйлсийг анхааран үзсэн билээ.

Зүүн хойт Азийн бүс нутгийн улс орнуудын хооронд явагдаж буй үйл явцад идэвхтэй оролцох замд гарч байгаа манай улс энэ бүс нутгийн улс орнуудын дотор өвөрмөц байр суурийг эзэлж байна. Монгол улс бол 2 сая гаруй хүн амтай 1 сая 500 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, цаг уурын эрс тэс улиралтай, 25 сая орчим толгой малтай, аж үйлдвэр, зам тээвэр, харилцаа холбоо төдийлөн хөгжөөгүй, далайд

гарцгүй нийм орон юм. Манай улс цаашид хөгжил дэвшлээ түргэсгэхэд суурь болох давуудаг талуудтай. Тухайлбал зохих хэмжээний байгалийн нөөц байдагтай, авсаархан эдийн засагтай, мал аж ахуйн түүхий эдийн бүтээгдэхүүн ихтэй, үр тариа, хүнсний ногоогоор өөрийгөө хангах бүрэн бололцоотой, үр ашиг багатай ч гэсэн цөөн тооны үйлдвэртэй, хүн амын боловсролын төвшин нэг ч их доогуур биш, бас ч гэж бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчинтэй, хоёр их зах зээлийн дунд оршдог юм.

Монгол орон нүүдэлчин ард түмний соёл иргэншлийг хадгалж, нийт хүн төрөлхтний өмнө түүхэн их хариуцлага хүлээж тэрхүү үүргээ олон зууны туршид нэр төртэй гүйцэтгэж ирсэн билээ. Нүүдлийн бэлчээрийн мал аж ахуй нь экологийн цэвэр бүтээгдэхүүнийг хаягдалгүй технологиор боловсруулж, эрчим хүч дээд зэргээр хэмнэх, байгаль орчинтойгоо харилцан тэтгэх битүү хэлхээ үүсгэдэг онцлогтой юм. Нүүдлийн соёл өв уламжлалаа орчин үеийн аж үйлдвэрийн техникийн ололттой хослуулан, байгаль орчинтойгоо эвсэн зохицож хөгжих асуудал өнөөдрийн нэн тулгамдсан зорилтын нэг болж байна. Унаган төрхөө хадгалсан, онгон цэвэр байгаль орчинтой Монгол орныг олон улсын хамгаалалттай, дэлхийн шим мандлын тусгай бүс болгох саналыг саяхан 1992 оны зургаадугаар сард Бразилийн нийслэл Рио-де-Жанейро хотноо болсон Байгаль орчин, хөгжлийн асуудлаархи НҮБ-ын бага хурал дээр манай Засгийн газраас дэвшүүлсэн юм. Энэ санал дэлхийн олон нийт, эрдэмтэн судлаачдын дэмжлэгийг олно гэдэгт итгэж байна.

Дэлхийн улс орнууд, ялангуяа хуучин социалист орнуудад өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийн нөлөөгөөр 80-90 оны зааг дээр Монгол орны өмнө өнгөрсөн замаа шүүмжлэлтэй эргэн харж, цаашдын хөгжлийн замдаа бүтээлчээр хандах шинэ бололцоо нээгдсэн юм. Монголын түүхэнд гараагаа эхэлсэн огцом эргэлтийн энэхүү шинэ үе нь хүний эрх чөлөөг хүндэтгэх, нийгмийн амьдралыг ардчилах, улс орны хөгжлийн загварыг өөрчлөх явдлаар тодорхойлогдох билээ. 1990 онд анх удаа олон намын оролцлоготойгоор парламентын сонгууль явуулж төрийн дээд байгууллагыг сонгов. Хэд хэдэн намын төлөөлөгчид оролцсон Засгийн газар байгуулагдаж, хөтөлбөрөө боловсруулан үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд энэ үйл ажиллагааны гол зорилт нь улс орны эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх явдал байлаа. Монгол орны өнөөгийн дүр төрх бол хөгжлийнхөө замналыг шинээр сонгож энэ хорвоод хөдөлмөр зүтгэл, авьяас чадлаараа амь зууж сурах гэсэн монгол түмний чин хүсэл зоригийн илэрхийлэл болж байна. Ийнхүү хүн төрөлхтний эдүгээ цагийн нийтлэг жам ёсыг Монгол орон дагаж эхлэв. Үүнийгээ баталгаажуулсан шинэ Үндсэн хуулиа батлан хэрэгжүүлж түүний үндсэн дээр Монголд Улсын Их Хурлын сонгууль 1992 онд амжилттай явагдаж шинэ Засгийн газар байгуулагдан өөрийн үйл ажиллагааны Мөрийн хөтөлбөрөө тунхаглав. Шинэ засгийн газрын бодлого нь нэгэнт эхэлсэн ардчилал шинэчлэлийн үйл явцыг монголын ард түмний язгуур эрх ашгийн үүднээс цаашид улам гүнзгийрүүлнэ гэдэгт итгэж байна.

Өнгөрсөн хоёр жилд Монгол орон зах зээлийн харилцаанд шилжихэд хэд хэдэн чухал ахиц гарав. Иймэрхүү ахицын нэг нь эдийн засгийн гол салбар болсон хөдөө аж ахуйг зах зээлийн харилцаанд үндсэнд нь шилжүүлсэн явдал юм. Хөдөө нутагт өрнөсөн өмч хувьчлэлийн явцад хувийн өмчид мал сүргийн дийлэнх хувь нь шилжив. Энэхүү шинэ бөгөөд өргөн олныг хамарсан том үйл ажил богино хугацаанд шуурхай хэрэгжсэн боловч зарим алдаа гажуудлаас ангид байсангүй. Эдүгээ түүнийг засаж залруулах талаар Засгийн газраас эрчимтэй арга хэмжээ авч байна. Өмч хувьчлал худалдаа үйлчилгээний бүх анхдагч нэгжид явагдан дууслаа. Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газруудын нэлээд хувь нь хувьчлагдаад байна. Гэвч төрийн өмчийг хувьчлах асуудал, ер нь өмчийн олон хэлбэрүүдийг чөлөөтэй хөгжүүлэх асуудлыг тойрсон үзэл бодлын маргаан явагдаж зарим үед улс төрийн өнгө аястай болох хандлага ч

ажиглагдаж байв.

Хэрэглээний хүрээнд чөлөөт үнийг хэрэглэх явдал зах зээлийн харилцаанд шилжих үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болж байна. 1992 оны эхнээс гурил, талх, орон сууцны хөлс, хотын тээвэр, цахилгаан эрчим хүчнээс бусад үйлчилгээний үнийг чөлөөт үнэд шилжүүлэв. Гэвч төр, засгаас санхүү-валютынхаа бодлогыг ул үндэстэй боловсруулж тууштай явуулж чадаагүй, чөлөөт үнэд хэт огцом шилжиж орсон зэрэг нь зарим сөрөг үр дагавар авч ирсэн юм.

Эдийн засгийн дэд бүтцийг шинээр бий болгоход чиглэсэн бодлого явуулав. Татварын шинэ тогтолцоо, банкны хоёр шаттай тогтолцоог бий болгосон бөгөөд улсын төв банкны зэрэгцээ арилжааны болон хувийн банкууд байгуулагдан ажиллаж байна. Валютын ханшийг өөрчлөн экспорт, импортын тооцоонд нэгдсэн ханш хэрэглэх боллоо. Хөрөнгийн болон таваарын биржүүд ажиллаж эхэллээ.

Зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөөгийн шинэ нөхцөлд улс орны эдийн засгийн хөгжлийн шинэ үндсийг бүрдүүлэх салбаруудыг тэргүүлэн хөгжүүлэх, түүний найдвартай ажиллагааг бэхжүүлэх асуудалд Засгийн газар нэлээд анхаарал тавьж хүчин чармайлтаа дайчлан үйлдвэрлэл хөгжүүлэх, технологийг шинэчлэхэд чиглэгдсэн нэлээд тооны төсөл боловсруулж заримыг нь хэрэгжүүлэх эхлэл тавигдлаа.

Засгийн газар Монголын эдийн засгийн тодорхой салбар, тухайлбал түлш эрчим хүч, экспортын салбарыг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн тээврийн салбарыг техникийн хуучралыг гэтлэх, эдийн засгийн дэд бүтцүүдийг хөгжүүлэхэд чиглэгдсэн дунд хугацааны төсөл хөтөлбөрөө томъёолсон бөгөөд тэдгээрийг 1993 оноос эхлэн Монголыг дэмжигч орнууд, олон улсын эдийн засгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх юм.

Шинээр бүрэлдэж буй зах зээлийн харилцааг хууль эрхийн үндэстэй болгох үүднээс хэдэн арван хууль эрхийн актуудыг батлан мөрдөж байна.

Энэ бүхний үр дүнд Монголын нийгмийн амьдралын бүх тал хөдөлгөөнд орон өөрчлөгдөж, улс орны эдийн засаг зах зээлийн харилцаанд шилжих үйл явц эргэлт буцалтгүй болж, өөрийн хөдөлмөр тэмцлээр хөгжин дэгжихээс өөр замгүй гэсэн ухамсар монгол хүний оюун бодолд төлөвшин тогтож эхэлж байна.

Гэвч зах зээлд шилжих үйл явц ихээхэн хүнд төвөгтэй нөхцөлд явагдаж, үлэмжхэн зөрчлийг даван туулж өрлөн урагшилж байна. Энэ үйл явц өрнөсөн хугацаанд, ялангуяа хэрэглээний чөлөөт үнийг мөрдөж эхэлсний дараа улс оронд бараа таваарын хомсдлын хямрал эрс гүнзгийрч, төгрөгийн ханш асар ихээр унаж, олон түмний аж амьдралыг доройтуулж байгаа нь нийгмийн дотор бухимдал дургүйцлийг төрүүлж байна.

Эдийн засгийн энэ хүндрэлийн зэрэгцээ ардчиллын нэрийн дор нийгмийн дэг журам алдагдаж, эмх замбараагүй байдал ноёрхох зэрэг элдэв сөрөг үзэгдэл гарч, хүн амын дунд бүтээлч хөдөлмөрөөс зайлсхийх хандлага газар авах болов. Төр, Засгийн зохион байгуулах, хянан шалгах үүрэг хариуцлага цэлгардаж, түүний бодлого, үйл ажиллагаанд алдаа эндэгдэл гарч, улс төрийн намуудын маргаан зөрчил гүнзгийрсэн зэрэг хүчин зүйлс нь нийгмийн амьдралын бүх салбарыг хамарсан хямралыг гүнзгийрүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Энэ бүхэн нь эцсийн бүлэгт улс орны байдлыг тогтворгүй болгох аюулыг өөртөө агуулж байна.

Шинээр сонгогдсон Улсын Их Хурал, Засгийн газар өнгөрсөн хоёр жилийн туршлагаас хичээл сургаж авч, цаашдын үйл ажиллагааны үзэл баримтлалаа оновчтой болгон тодорхойлох нь чухал гэж үзнэ. Улс орны төр, засгийн удирдлагыг бэхжүүлж зохих байранд нь тавих, хууль ёсоо дээдлэн сахиж, эмх замбараагүй байдлыг арилган дэг журмыг тогтоох нь юу юунаас чухал боллоо.

Манай төр, Засгийн анхаарлын төвд байвал зохих асуудал бол улс

орны өнөөгийн эдийн засгийн уналтыг зогсоож, түүнийг хямралаас гаргах явдал мөн. Энэ зорилтыг хичнээн богино хугацаанд шийдэж чадна, төчнөөн хурдан эдийн засгаа өөд татах суурь үндэс тавигдана. Үүний тулд өнөөгийн эдийн засгийн тогтолцоог даруй эмхлэн цэгцэлж, зах зээлийг баримжаалсан, өөрийн онцлогийг харгалзсан хөгжлийн үзэл баримтлалаа тууштай ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Манай шинэ Засгийн газар нийгмийн үйлдвэрлэлийн салбарт онцгой анхаарч ард түмнийхээ авьяас чадвар, бүтээлч хөдөлмөрийг энэ чиглэлд зохион байгуулан идэвхжүүлэх, гадаад орны зээл, тусламжийг үр ашигтай зарцуулах эрчимтэй механизмыг буй болгон хэрэгжүүлэх нь нэн чухал болоод байна.

Нийгмийн сэтгэхүйг өөрчлөн шинэчлэх ажил явагдаж байгаа нь өнөөгийн чухал түүхэн үйл явц билээ. Гэхдээ өнгөрсөн жилүүдэд бий болгосон хүн ардын оюуны потенциалыг алдалгүй хадгалан хамгаалж цаашид арвижуулах, соёл, боловсрол, урлаг, шинжлэх ухааны өнөөгийн тогтолцоог зөвөөр залан чиглүүлж, өөрийн үндэсний бv уламжлал, нийт хүн төрөлхтний соёл иргэншлийн үнэт зүйлсийн ололтын суурин дээр хөгжүүлэх явдал Монгол орны шинэ хөгжлийн нэг чухал шийдвэрлэх хүчин зүйл мөн билээ.

Улс орны туулан өнгөрүүлж байгаа шилжилтийн үеийн дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд хөрөнгө чинээтэй, хөгжсөн орнуудын тусламж дэмжлэг нэн чухал. Дэлхийн дайны дараа Европ дахиныг хөл дээр нь босгоход "Маршалын төлөвлөгөө" их тус болсныг бид мэдэх билээ. Өнөө үед хуучин ОХУ, Дорнод Европын орнууд ивээлтэй нийгэмд шилжиж хямралаас гарахад нь өрнөдийн орнуудын дэмжлэг чухал болж байна. Үүний нэгэн адил манай оронд тохиолдсон хямралыг даван туулахад хандивлагч орнуудын зээл тусламж чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй. Одоо Монгол улс Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүн болсон бөгөөд манай Засгийн газар тэдгээр байгууллагатай зах зээлийн харилцаанд шилжих хөтөлбөрөө зохицуулан тохиролцож, хамтран ажиллахад анхаарлаа төвлөрүүлж байна. Үүнийг 1991 оны есдүгээр сарын эхээр Японд болсон дэлхийн 14 улс болон олон улсын 5 байгууллага оролцсон Монголыг дэмжигч орнуудын уулзалт, 1991 онд Улаанбаатар хотноо НҮБ-ын ивээл дор болсон Монголыг дэмжигч орнуудын анхны Зөвлөлгөөн, 1992 оны 5 дугаар сарын эцсээр 17 орон, 5 олон улсын байгууллага оролцсон Монголыг дэмжигч орнуудын Токногийн 2 дугаар уулзалт илтгэн харуулж байна. Эдгээр орны тусламж, хөнгөлттэй зээл 1991 онд 160 сая ам. доллар байсан бол 1992 оны сүүлний хагас, 1993 онд 320 сая ам. доллар болж нэмэгдэж, үр нөлөө нь дээшлэв. 4

Манай улс Зүүн хойт Азийн олон улсын харилцаа, хамтын ажиллагааны үйл хэрэгт оролцож эхлэхдээ эн тэргүүнд бүс нутгийн орон тус бүртэй хоёр талын харилцаа, харилцаа ашигтай хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх, түүгээр дамжин цаашид олон талын хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграцийн үйлст оролцох явдлыг анхаарсан юм. Сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд манай улсаас бүс нутгийн орнуудтай харилцааг өргөтгөх тодорхой алхмууд хийж, олонхитой нь төр засгийн хэмжээнд төлөөлөгч солилцон яриа хэлэлцээ хийж, заримтай нь худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбарт хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байна.

Монгол улсаас Зүүн хойт Азийн орнуудтай тогтоосон худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны зарим асуудлыг товч хөндье. *

Монгол улсыг тогтвортой байдалд хөгжүүлэхэд юуны өмнө хоёр хөрш, уламжлалт түншүүдтэйгээ ойр дотно, найрамдалт харилцаатай

* Монгол улсаас Зүүн хойт Азийн орнуудтай тогтоосон худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны тухай худалдаа үйлдвэрийн яамнаас 1992 оны эхний хагаст гаргасан тоо баримтыг энд ашиглан.

байх нь нэн чухал. Гэхдээ энэ нь шинэ маягийн харилцаа байх учиртай.

Тусгаар тогтнон Оросын Холбооны Улстай бүх талын уламжлалт харилцаагаа бид хадгалан барьж, түүний дэмжлэгийг хүлээн авах явдал цаашдаа ч гэсэн манай улсын улс төрийн тусгаар тогтнол, эдийн засгийн хөгжилд үлэмж чухал ач холбогдолтой байх болно. Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн бусад улстай өргөн харилцаатай байхыг бид эрмэлзэнэ. 1992 оны эхээр Монгол улсын Ерөнхий сайд, дараа нь Гадаад харилцааны сайд Орос улсад айлчилж Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны тулгамдсан асуудлаар Оросын удирдлагатай санал солилцов.

1992 оны 12 дугаар сарын сүүлчээр Монгол, Оросын засгийн газар хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны анхдугаар хуралдаан болж, шийдвэрийн хэрэгжилтийн талаар санал солилцож, 1993 оны худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Протоколд гарын үсэг зуржээ. Түүнчлэн Орос улс манай барилга байгууламжид зориулан 38,7 сая ам. долларын зээл олгохоор болсон билээ. Хоёр талын хүчин чармайлт, идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд Монгол, Орос улсын хооронд шинэ гэрээ байгуулах бэлтгэл ажил дуусч хоёр орны гадаад харилцааны сайд нар үзэглэсэн бөгөөд Монгол улсын ерөнхийлөгч ОХУ-д айлчлах үед гарын үсэг зурах болно.

Хил залгаа Буриад, Тува улс, Чита мужтай гэрээ хэлэлцээр байгуулж худалдаа, эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах болсноор шинэ маягийн харилцааны эхлэлийг тавилаа. Монголын Сэлэнгэ аймаг, Буриадын Хиагтын дүүрэгт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах чиглэлд хамтран ажиллаж эхлэв. Манай улс Оросын Холбооны улсын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарцтай болох, тус улсын далайн 20 боомтыг ашиглах тухай хэлэлцээр байгуулав.

Сүүлийн 2 жилд Оросын Холбооны улстай хамтарсан хөрөнгө оруулалт хийсэн 47 үйлдвэр, аж ахуйн газар байгуулагдлаа. Тэдгээрийн дүрмийг санд 12 сая 242 мянган ам. долларын хувь хөрөнгө Оросын тал оруулагд байна. Аль эль нь өөрчлөлт шинэчлэлтийн хэцүү замаар замнаж явгатай холбогдон хоёр орны харилцаанд олон талын бэрхшээл, хүндрэл гарч байгаа боловч түүнийг манай хоёр ард түмний бие биендээ итгэх итгэлийн хүчээр тэвчиж, түүхийн сорилтыг давж чадна гэдэгт бид итгэл төгс байгаа билээ.

Монгол, Хятадын харилцаа улс төр, эдийн засаг, соёлын олон салбарт өргөжин хөгжиж байна. 1991 онд БНХАУ-ын төрийн тэргүүн Монгол улсад, Монгол улсын ерөнхий сайд Хятад улсад айлчилсан явдал хоёр орны харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чухал үйл явдал болсон юм. Айлчлалын үеэр хоёр орны хамтын ажиллагаанд чухал ач холбогдол бүхий Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд байгуулагдлаа.

Энэ оны эхээр эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын засгийн газар хоорондын комиссын хоёрдугаар хуралдаан болж БНХАУ-аас Монгол улсад олгохоор болсон 50 сая юанийн урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг жилд 6 мянган тонн цэвэр үйлдвэрлэх үйлдвэр, төмрийн хүдрийн хамтарсан үйлдвэр, пүнгүүз үйлдвэрлэх, хагас үнэг чулуу боловсруулах үйлдвэр байгуулахад тус тус ашиглахаар болов. Үүний зэрэгцээ хоёр орны адил төрлийн яам, газар, муж, хот, өөртөө засах орон болон гадаадтай харилцах эрх бүхий байгууллагын шууд харилцааг дэмжиж, хамтын ажиллагааны дэвшилтэт шинэ хэлбэрийг эрэн сурвалжлахаар тохиролцлоо. 1991 оны байдлаар хоёр талын нийт бараа эргэлт 37 сая гаруй ам. долларт хүрчээ. Хятад улс манай оронд 10 нэр төрлийн хүнсний болон өргөн хэрэглээний барааг тусламж болгон энэ оны эхээр нийлүүлжээ.

Хил залгаа Өвөр Монгол, Шинжаантай бүс нутгийн худалдаа, хамтын ажиллагаа өргөжиж, хэд хэдэн хилийн боомтыг шинээр нээв. БНХАУ-ын тусламжтайгаар манай улс далайд гарцтай болж Монголын далаагаар хөлөг онгоц Номхон далайд хөвөх боллоо.

1992 оны эхний хагасын байдлаар Монголд Хятадын хөрөнгө оруулалтаар 27 хамтарсан үйлдвэр, аж ахуйн газар байгуулагдаж тэдгээрийн дүрмийн санд Хятадын талаас нийтдээ 3 сая 38 мянган ам. долларын хувь хөрөнгө оруулаад байна.

Монгол улсын ерөнхийлөгч 1990 онд Япон улсын эзэн хааныг хаан ширээнд залах ёслолд оролцсон. Япон улсын Ерөнхий сайд манай оронд анх удаа 1991 онд айлчилсан зэрэг нь манай хоёр орны харилцан итгэлцлийг бэхжүүлж, хамтын ажиллагааны ирээдүйн хөгжлийн үндсийг тавихад ач холбогдолтой боллоо. Японы Ерөнхий сайдын айлчлалын үе эр хоёр орны харилцааг цаашид хөгжүүлэх зарчмыг тодорхойлж, ойрын үед эдийн засгийн салбарт хамтран ажиллах чиглэлийг тохиролцсон юм.

Монгол, Японы худалдаа, эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хүрээнд Дарханд хар төмөрлөгийн жижиг үйлдвэр барих, зарим дулааны цахилгаан станцуудын тоног төхөөрөмж болон нүүрсний уурхайн тээврийн машины паркийг шинэчлэх ажил явагдаж байгаа бөгөөд үүнд Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ЖАЙКА/ оролцож байгаа юм. Монгол Японы холбогдох байгууллагууд уул уурхай, хөнгөн хүнсний үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг салбарыг хөгжүүлэхэд чиглэгдсэн 35 төслийн хүрээнд хамтарсан судалгаа хийж байна.

Япон улс 1991 онд Монголд 61 сая ам. долларын тусламж үзүүлсэн бөгөөд түүний 35 сая нь урт хугацааны хөнгөлөлттэй зээл байсан бол 1992 онд 75 сая ам. долларын тусламж, зээл олгохоор болсны 28 сая нь буцалтгүй тусламж, үлдэх хэсэг нь 50 сая ам. доллартай тэнцэх нөхөн хөнгөлөлттэй зээл байх юм. Буцалтгүй тусламжийн хүрээнд олон улсын холбооны "Интелсат" газрын станцыг байгуулах болов. Түүнчлэн эмнэлгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийн тусламж үзүүлж, тэдгээрийг суурилуулах ажил хийж байна. Японы компани пүүсүүдээс Монголтой харилцах харилцааны баталгаа болгон 100 сая ам. долларын даатгалын баталгаа гаргасан юм.

1992 оны эхний хагасын байдлаар Монгол Японы хамтарсан хөрөнгө оруулалтаар 6 үйлдвэр, аж ахуйн газар байгуулагдаж тэдгээрийн дүрмийн санд Японы талаас нийтдээ 368 мянган ам. долларын хувь хөрөнгө оруулаад байна.

Япон улс нийнхүү тус улсад тусламжаа дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ Зүүн хойт Азийн бүс нутгийн орны хувьд Монголд үзүүлэх олон улсын тусламжийг зохион байгуулах үүднээс хандивлагч орнуудын хүч чармайлтыг зохицуулах үүрэг өөртөө хүлээж тэр үүргээ нэр төртэй биелүүлж байна.

1987 онд Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосноор хоёр орны харилцаа өргөжин хөгжих эхлэл тавигдаж улс төрийн яриа хэлцэл тогтмолжиж байна. 1990-1991 онд Монгол улсын ерөнхийлөгч, Ерөнхий сайд, ГХЯ-ны сайд нар АНУ-д, АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга манай оронд тус тус айлчилсан нь хоёр орны харилцааг шинэ шатанд гаргасан чухал ач холбогдолтой үйл явдлууд болсон юм. Айлчлалын явцад байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд Монгол, Америкийн харилцааны эрх зүйн үндсийг тавьсан юм. Монгол, АНУ-ын хооронд консулын харилцаа, худалдаа, хөрөнгө оруулалт, шинжлэх ухаан-техник, соёл боловсролын салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын арваад хэлэлцээр, хоёр орны байгууллага, пүүс, компанийн хооронд хамтран ажиллах 20 шахам хэлэлцээр, протокол байгуулагдсан юм.

Худалдааны хэлэлцээрээр хоёр тал бие биедээ нэн тааламжтай байх нөхцөлийг харилцан олгож тус тусын зах зээлд харилцан бараа нийлүүлэхэд гаалийн хийгээд бусад хөнгөлөлт үзүүлэх болов. Монголд орчин үеийн үйлдвэрлэл хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхэд чиглэгдсэн тэмээний ноос, сарлагийн хөөвөр боловсруулж бэлэн бүтээгдэхүүн гаргах, "Голштейн" үүлдрийн үнээ үржүүлэх, нефтийн хайгуул хийж

олборлох чиглэлээр хоёр талын холбогдох пүүс компаниуд хамтран ажиллаж эхлэв. Уул уурхай, эрчим хүчний салбарт хамтран ажиллах боломжийг судалж байна.

АНУ-ын хувийн пүүс, компани, үйлдвэр, бусад байгууллагыг Монголын түншлэх газруудтай холбож өгөх зорилгоор АНУ-д "АНУ-Монголын бизнесийн зөвлөл", "АНУ-ын Монголын зөвлөх бүлгэм" гэдэг хувийн бие даасан хоёр байгууллага үүсч үйл ажиллагаагаа эхэллээ. 1991 онд АНУ-ын Засгийн газрын байгууллага-Олон улсын хөгжлийн агентлаг 9 орчим сая долларын хүнсний, 10 сая долларын санхүүгийн тусламж, мөн өөрийн санаачилгаар 2,4 сая долларын техникийн тусламжаа үзүүлэв. Санхүүгийн тусламжийн хөрөнгийг уурхайн болон цахилгаан станцуудын энэ төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, хүнд даацын машин, бусад шаардлагатай бараа материал худалдан авахад зарцуулж байгаа билээ. Монгол-Америкийн хамтарсан үйлдвэр, аж ахуйн газрын дүрмийн санд америкийн тал 6 сая 620 мянган ам. долларын хувь хөрөнгө оруулжээ. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтсоноос хойш Монгол, Бүгд Найрамдах Солонгос Улсын эдийн засаг, худалдаа, соёлын харилцаа хөгжих үндэс суурь тавигдав. Монгол улсын Ерөнхийлөгч, ГХЯ-ны сайд БНСУ-д, БНСУ-ын ГЯЯ-ны сайд Монголд хийсэн айлчлалын үеэр байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд нь хоёр орны харилцааны эрх зүйн үндсийг тавьсан юм.

Хоёр орны хооронд хөрөнгө оруулалт, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл боловсролын хамтын ажиллагаа, иргэний агаарын тээврийн харилцаа болон давхар татвараас харилцан чөлөөлөх тухай зэрэг гэрээ хэлэлцээр байгуулагдав. Эдгээр гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад Солонгосын ДЭУ, Хөндэ, Самсунг зэрэг томоохон пүүсийн төлөөлөгчид Монголд айлчилж манай холбогдох байгууллагуудтай уулзан хамтран ажиллах талаар судалгаа хийж, санал солилцож байна.

1991 онд манай ерөнхийлөгч БНСУ-д айлчлах үеэр Солонгосын тал 10 сая долларын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн билээ. Энэ зээлийн хөрөнгийг манай улс нэг удаагийн тариурын болон хавтгай шилний үйлдвэр байгуулахад зориулахар төлөвлөж байна. БНСУ манайд олгох 1 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хүрээнд өргөн хэрэгцээний бараа нийлүүлэхээр тохирсноо хэрэгжүүлээд байна. Монгол, Солонгосын худалдааны эргэлт 1990 онд 2,5 сая ам. доллар байснаа 1991 онд 5,7 сая болж өсөв.

Монгол, БНАСАУ-ын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын харилцааг хөгжүүлэх өргөн бололцоо бий билээ. Өнөөдөр БНАСАУ-тай хамтарсан үйлдвэр, аж ахуйн газар байгуулах, хувь хүмүүсийн хооронд холбоо тогтоох үйл явц эхэлж байгааг бүх талаар дэмжин цаашид өргөтгөн хөгжүүлэх нь чухал. Монгол улс БНАСАУ-ын уламжлалт харилцааны суурь дээр шинэ маягийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал юм. Тухайлбал, эмийн ургамлын нөөцтэй манай хоёр орны тэдгээрийг шинжлэн судлах, тарьж ургуулах, хамтарсан эмийн үйлдвэр байгуулан бүтээгдэхүүнийг экспортлох, хүнсний ногоо тариалж боловсруулалт хийх, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэх мэт чиглэлээр хамтран ажиллаж болох юм.

Зүүн хойт Азийн өндөр хөгжилтэй орны нэг Канад улстай бид хамтран ажиллахыг эрмэлзэн эрэл хайгуул хийж байна. Тухайлбал хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбарт хамтран ажиллах боломжийг судлан энэ чиглэлд тодорхой алхам хийж, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг үйлдвэрүүдийг байгуулах талаар тохиролцож болох юм.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль батлагдсанаас хойшхи 2 жилийн хугацаанд 20 орноос /1992 оны эхний хагасын байдлаар / их бага хэмжээний хамтарсан хөрөнгө оруулсан 107 үйлдвэр, аж ахуйн газар манай улсад байгуулагдлаа. Тэдгээрийн дүрмийн санд гадаадын эрэлцөгчид хувь хөрөнгө болгон нийтдээ 27 сая 333 мянган ам. долларын

хөрөнгө оруулаад байна. Монгол улс гадаадын улс орнуудтай, тэдгээрийн дотор АНУ, Өмнөд Солонгос, Хятадтай хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөхүүлэн дэмжих гэрээ байгуулан ажиллаж байгаа нь аль аль талын ашиг сонирхолд нийцэж, эдийн засаг, санхүүгийн хамтын ажиллагааг өргөтгөхөд нааштай нөлөө үзүүлэх ач холбогдолтой билээ. Гадаадын хөрөнгө оруулалтын хувьд ажлын ийм эхлэл байгаа боловч өнгөрсөн 2 жилийн хугацаанд дорвитой хөрөнгө оруулалт үндсэндээ хийгдсэнгүй. Энд олон талын бэрхшээл, учир шалтгаан /манай орны тухай мэдээлэл, газарзүйн байршлал, эдийн засгийн дэд бүтцийн хөгжилт зах зээлийн багтаамж зэрэг/ байгааг бид бодитой ойлгож байна.

Ийнхүү Монгол улс Зүүн хойт Азийн орнуудтай эдийн засгийн талаар хамтран ажиллаж эхэлж байгаа нь олон талын ач холбогдолтой юм. Энэ нь Монголын эдийн засгийг хямралаас гаргах, бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Монголыг татан оруулах, манай улсад шинэ техник технологид үндэслэсэн үйлдвэрлэлийн зарим салбарыг хөгжүүлэхэд нэн чухал тус дөхөм үзүүлэх юм гэж бид үзэж байна.

Монгол улс соёл боловсрол, шинжлэх ухааны салбарт бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах явдалд эдийн засгийн хамтын ажиллагааны нэгэн адил чухал ач холбогдол өгч энэ чиглэлээр эргэн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Монгол орон хөгжлийн шинэ замд орж буй энэ үед улс орноо залан жолоодох удирдлагын урлагийг эзэмшсэн мэргэжлийн боловсон хүчинтэй байх явдал юу юунаас ч чухал болж байна. Улс оронд байгаа нэгэнт бэлтгэгдсэн боловсон хүчнийг зах зээлийн шаардлагад зохицуулан шинээр мэргэжүүлэн, ийгмийн шинэ харилцааг өвөгсөтэй эрхлэн хөглөх дадлага туршлага олгох чухал үйлэт бид өндөр хөгжилтэй түнш орнуудын тусламж дэмжлэг авч эхлэв. Мөн түүнчлэн жижиг үйлдвэрлэл, бизнес эрхлэх арга ажиллагаа, менежмент, банк, цахим техник гэх зэрэг салбарт өндөр мэргэжлийн боловсон хүчин шинээр бэлтгэх зорилгоор Япон, АНУ, Өмнөд Солонгос зэрэг оронд оюутан, аспирант суралцуулж эхлэв. Манай орны оюуны потенциалыг арамжуулахад чухал ач холбогдолтой энэ үйлэт дээр дурдсан орнуудын зэрэгцээгээр ИУБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, ийгмийн комисс, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллага зохих тусламж дэмжлэг үзүүлж байна. Боловсролын салбарт Монгол Зүүн хойт Азийн орнуудын байгууллага хоорондын шууд хэлхээ холбоо ч өргөжиж байна.

Соёлын хамтын ажиллагаа тус орны хөгжлийн нэг чухал хүчин зүйл учраас Монгол улс бүс нутгийн орнуудтайгаа соёлын харилцаа хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Зүүн хойт Азийн орнуудын соёлын харилцаанд мэдэгдэхүйц ахиц гарч, урлагийн хамтлаг айлчлуулах, үзэсгэлэн гаргах, кино солилцох зэргээр улс орноо сурталчлах, бие биенээ харилцан ойлголцох чиглэлээр тодорхой ажил өрнөж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Манай улсын эрдэм шинжилгээний байгууллагуудаас бүс нутгийн орнуудын ижил төрлийн байгууллагуудтай тогтоож буй холбоо хэлхээг цаашид агуулга, хэлбэрийн аль аль талаас өргөтгөн төрөлжүүлэх, үйл ажиллагааг нь идэвхжүүлэхийг шинэ нөхцөл байдал шаардаж байгаа юм. Даврамд тэмдэглэхэд бид шинээр хэлхээ холбоог хөгжүүлж буй улсууд бүү хэл, олон жил холбоотой байсан том хөршүүдийнхээ өнөөгийн сайдлын талаар бага ойлголттой байгаа учир орон судлалыг бий болгон хөгжүүлэх нь чухал болж байна. Үүний хамт улс орныхоо өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаар бүс нутгийн олон нийтэд мэдээлж, эх орноо сурталчлах явдал эрдэм шинжилгээний байгууллагуудын гүйцэтгэх бас нэг үүрэг юм. Энэхүү үүрэг, харуцлагыг иш үндэс болгон манай Зүүн хойт Ази судлалын төв бүс нутгийн ижил төрлийн эрдэм шинжилгээний байгууллагууд, тухайлбал ЗХУ /хуучин нэрээр/, БНХАУ, АНУ, БНСУ-ын хэд хэдэн хүрээлэн, тэвтэй холбоо тогтоон, талархалд оролцон, заримтай нь

хамтын ажиллагааны төлөвлөгөөг тохиролцон, хэлэлцээр байгуулахын хамт, тэдгээр оронд зохиогдсон эрдэм шинжилгээний бага хурал, уулзалтад оролцон, ийм арга хэмжээг өөртөө зохиов.

Тус Төвийн эрдэмтэд Ази, Номхон далайн болон түүний Умард бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагаа, ирээдүйн төлөв, ЗХУ /хуучин нэрээр/ -ын Алс Дорнодын бүс нутгийн хөгжил, Түмэн голын сав газрыг эзэмших төсөл, Зүүн хойт Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа зэрэг асуудлаар Москва /1991/, Гонолул /1991/, Чанчун /1992/, Владивосток /1992/ хотод болсон олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Бээжинд /1991/ болсон Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны иргэдийн нийгэмлэгийн анхдугаар их хуралд тус тус оролцсоны дээр Дорно дахин, олон улсын судлалын хүрээлэнтэй хамтран тээвэр холбоо, жуулчлалын асуудлаар Зүүн хойт Азийн орнуудын эрдэмтэд мэргэжилтний уулзалт /1991/, БНСУ-ын Хөнхийн их сургуультай хамтран XXI зууны дэлхийн шинэ дэг журамд Зүүн хойт Азийн эзлэх байр сэдвээр бага хурал /1992/ Улаанбаатарт зохиосон зэргийг үүний й жишээ баримт болгон дурдаж болох юм. Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны иргэдийн нийгэмлэгийн их хурлаар манай бүс нутгийн эрдэмтэд-эдийн засагчдын байнгын байгууллагыг бий болгож, судалгааны ажлын хүрээг тодорхойлон, нийгэмлэгийн хамтын хөрөнгийн санг бүрдүүлэх тухай шийдвэрлэсэн нь манай бүс нутагт эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг хөгжүүлэхэд цаашдын ач холбогдолтой үйл явдал боллоо.

Дээр дурьдсан баримт сэлт нь Зүүн хойт Азийн орнуудын Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагуудын хүрээнд, мөн түүнчлэн бүс нутгийн иргэний байгууллагуудын хооронд хамтын ажиллагааны үзэл санаа дэлгэрэн хөгжиж, энэ чигт бодит үйл ажиллагаа идэвхжиж, түүнд Монгол улс өнөөгийн хэр чинээ, бололцосгоороо оролцож байгааг харуулж байна.

Ази, Номхон далайн бусад бүс нутагт бий болсон олон талын хамтын ажиллагааны байгууллагууд шиг биежин хэлбэржсэн албан ёсны байгууллагууд Зүүн хойт Азийн бүс нутагт хараахан байгуулагдаагүйгээс олон талын санал бодол, бодит хэрэгцээг тусгасан чиглэл, зөвлөмж, тосцоо, судалгаа, дүн шинжилгээ илт үгүйлэгдэж байгаа нь ойлгомжтой. Тус бүс нутгийн зарим орны төр, засгийн зүтгэлтнүүд бүс нутагтаа олон талын хамтын ажиллагааны шинэ бүтэц, механизм, байгууллагыг үүсгэн бий болгох, иймэрхүү асуудлыг олон талын уулзалтаар хэлэлцэх санал нэг бүс удаа тавьж байгаа нь бодит байдал дээр биежиж байгаа хамтын ажиллагааг зохион байгуулалтын хэлбэрт оруулах гэсэн эрмэлзлэлийн илрэл бизээ.

XX зуун дуустал 10 хүрэхгүй жил үлдэж байна. Энэ арваад жилд бид XXI зуунд хамтран амьдрах үйлснийхээ эх суурийг тавих ёстой.

Энэ 10 жилд эсрэг тэсрэг системийн хоорондын тэмцэл түүх болон үлдэх нь ээ. Тэгээд дэлхийн бүх улс орон нийт хүн төрөлхтний асуудлуудыг шийдвэрлэх, хүн ардын хэвийн амьдрал, хүмүүнлэг ёсыг хангах зорилгоор хамтран ажиллах болно.

Энэ 10 жилд улс орнууд хоорондоо зөвсөг бэрин дайсгалцах явдал бас түүх болон үлдэх нь ээ. Тэгээд дэлхийн бүх улс орон хоорондоо түншүүдийн ёсоор харилцаж, улс төрийн аргыг өөр хоорондын санал зөрөлдөөнийг шийдвэрлэх хэрэгсэл болгон ашиглах, цөмийн зэвсгийг үстгах, хүч хэрэглэх явдлыг олон улсын харилцаанаас зайлуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх болно.

Зугуухан хэрэгжиж эхэлсэн энэхүү түүхэн өөрчлөлтийн явцад бид хамтын ажиллагаагаа өрнүүлэн хөгжүүлж, дэлхийн шинэ дэг журмыг тогтоох чигт урьд хэзээ ч хийгээгүй аажмууд хийж чадна гэсэн итгэл найдвар төрж байна. Өнөөгийн өөрчлөгдөж байгаа нөхцөлд ондөр хөгжилтэй Орнод Европын орнуудыг нэгтгэсэн Европын хамтын нийгэмлэг нь Дорнод Европын орнуудын хамтаар нийт Европын хамтын гэр орон босгохоор зориглон хөдөлж Европын нэгдмэл зах зээл байгуулах төслийг

эрчимтэй хэлэлцэж байна. Умард Америк, Латин Америкийн орнууд тивчилсэн бүхэл бүтээн цогцос болон хамтран ажиллах тэмүүлэл нь хүч авах болов. Африк тивд ч ийм хандлагын эх суурь тавигдаж байна. Дэлхийн хамгийн уудам Ази тив, Номхон далайн сав газрын хамтын ажиллагаа Европтой харьцуулбал хоцорч яваа боловч энэ бүс нутагт намжмал байдал тогтоох, улс төр-цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-техникийн олон талын холбоо хэлхээг хөгжүүлэх үйл явц сүүлийн жилүүдэд дэлгэрэн идэвхжив. Олон улсын улс төр, эдийн засгийн харилцааг урагшлуулах, дэлхийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд тэргүүлэх роль гүйцэтгэдэг их гүрнүүдийг багтаасан Зүүн хойт Азийн бүс нутагт өргөн хамтын ажиллагааны бүтцийг бий болгон бүрэлдүүлэх нь дэлхий нийтийн ач холбогдолтой үйл явдал болох билээ.

Ийнхүү манай гаригийн бүс нутгуудад энх тайванч, хүч үл хэрэглэх үндсэн дээр тал бүрийн хамтын ажиллагааг хөгжүүлж, улмаар дэлхийн шинэ дэг журмыг тогтоох зүгт хүч чармайлт тавих нь хүн төрөлхтөн XXI зуунд оршин амьдрахын чухал нөхцөл болох юм.

1. "Үнэн" сонин, 1992 он, № 3, 44.
2. "Үнэн" сонин, 1992 он, № 3, 44.
3. "Ардын эрх" сонин, 1992 он, № 88.
4. "Засгийн газрын мэдээ" сонин, 1992 он, № 19.